

**УУЖИМХАНГАЙ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН
ТЭМДЭГЛЭЛ**

2018 оны 4 сарын 30 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Хурал 2018 оны 04 сарын 30 –ны өдрийн 11:00 цагт Монгол улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Жигжиджавын гудамж, 5/3 тоот Оффисын хоёрдугаар давхарын хурлын танхимд болов.

Хурлын ирц:

УУЖИМХАНГАЙ ХК –ийн нийт гаргасан 136,487 ширхэг хувьцаа байгаагаас 136,487 ширхэг саналын эрхтэй хувьцаатай бөгөөд хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн өдөр буюу 2014 оны 04 сарын 12 –ны өдрийн байдлаар нийт 140 хувьцаа эзэмшигч байна. Үүнээс 71,225 ширхэг хувьцаатай 3 хувьцаа эзэмшигч буюу 52.18 хувийн ирцтэй хувьцаа эзэмшигчдийн дийлэнх хуралд ирсэн тул хурал хүчин төгөлдөрт тооцогдов. Оролцсон хувьцаа эзэмшигчид:

№	Хувьцаа эзэмшигчийн овог нэр	Хувьцааны тоо ширхэг	Эзэмшил хувь
1		34,100	47.88%
2		27,000	37.91%
3	Лхагвын Золбаяр	10,125	14.22%
Нийт		71,225	52.18%

Хурлаар Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2018 оны 03 –р сарын 19 –ны өдрийн 02 тоот тогтоол болон хурлын дэгийн дагуу дараах асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэнэ. Үүнд:

Хэлэлцэх асуудал 1: Компанийн 2017 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан батлах тухай.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэсэн “УУЖИМХАНГАЙ” ХК –ийн 2017 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг батлах.

Шийдвэр 1:

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэсэн “УУЖИМХАНГАЙ” ХК –ийн 2017 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг БАТАЛСУГАЙ.

Хэлэлцэх асуудал 2: Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг сонгох тухай.

“УУЖИМХАНГАЙ” ХК –ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүдээр:

- Г.Хатанболд
- Г.Лхамсүрэн
- Б.Эрдэнэжаргал
- Д.Баярсайхан
- М.Мөнхзолбоо
- С.Шагдарсүрэн

“УУЖИМХАНГАЙ” ХК –ийн Төлөөлөн удирдах Зөвлөлийн хараат бус гишүүдээр:

- Д.Санжид

- Б.Амгаланбаатар
- Г.Даваа-Очир нарыг тус тус 1 жилийн хугацаагаар сонгох.

Шийдвэр 2:

1. "УУЖИМХАНГАЙ" ХК –ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүдээр:

- Г.Хатанболд
- Г.Лхамсүрэн
- Б.Эрдэнэжаргал
- Д.Баярсайхан
- М.Мөнхзолбоо
- С.Шагдарсүрэн

"УУЖИМХАНГАЙ" ХК –ийн Төлөөлөн удирдах Зөвлөлийн хараат бус гишүүдээр:

- Д.Санжид
- Б.Амгаланбаатар
- Г.Даваа-Очир нарыг тус тус 1 жилийн хугацаагаар СОНГОСУГАЙ.

Хэлэлцэх асуудал 3: Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны төсвийг батлах тухай.

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны төсвийг тэг төгрөгөөр батлах.

Шийдвэр 3:

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны төсвийг тэг төгрөгөөр БАТАЛСУГАЙ.

Хэлэлцэх асуудал 4: Компанийн оноосон нэрийг өөрчлөн батлах тухай.

"УУЖИМХАНГАЙ" ХК –ийн оноосон нэрийг "СТАНДАРТ АГРИКАЛЧЕР ГРУПП" ХК болгон өөрчлөх.

Шийдвэр 4:

1. "УУЖИМХАНГАЙ" ХК –ийн оноосон нэрийг "СТАНДАРТ АГРИКАЛЧЕР ГРУПП" ХК болгон ӨӨРЧИЛСҮГЭЙ.

Хэлэлцэх асуудал 5: Компанийн шинэчилсэн дүрмийг батлах тухай.

"УУЖИМХАНГАЙ" ХК –ийн шинэчилсэн дүрмийг хавсралт 1-р батлах.

Шийдвэр 5:

1. "УУЖИМХАНГАЙ" ХК –ийн шинэчилсэн дүрмийг хавсралт 1-р БАТАЛСУГАЙ.

Тэмдэглэл хөтөлсөн:



Б.ДЭЖИДМАА

Танилцсан Хурлын дарга:



Г.ХАТАНБОЛД